



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах, хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 346 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/125 дугаар тушаалын Дашдорж овогтой Чингисхүүтэй холбогдох хэсгийн “Боловсрол, магистр, 2 жил” гэснийг “Боловсрол, доктор, 3 жил” гэж, 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/391 дүгээр тушаалын хавсралтын Батжаргал овогтой Бэрстэй холбогдох хэсгийн “3 жил” гэснийг “4 жил” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/114 дүгээр тушаалын хавсралтын Энхбаатар овогтой Билгүүнтэй холбогдох хэсгийн “Cardiff University” гэснийг “University of South Wales” гэж, мөн тушаалын хавсралтын Соёл-Эрдэнэ овогтой Оюунжаргалд холбогдох хэсгийн “University of York” гэснийг “Griffith University” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/115 дугаар тушаалын Мөнхдалай овогтой Түмэнхүслэнд холбогдох хэсгийн “3 жил” гэснийг “4 жил” гэж тус тус өөрчилсүгэй.


2. Онондорж овогтой Анударийн Боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний хугацааг 1 жилээр, Элбэгсайхан овогтой Маралын суралцах хугацааг эрүүл мэндийн байгууллагаас олгосон баримт бичгийг үндэслэн суралцах хугацааг 1 улирлаар тус тус сунгасугай.

3. Иргэдтэй зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /Д.Гарди/-д,

14231 0388

энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар /Ш.Нарантуяа/-г тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН